


ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2020.02.24-2020.03.25/

НЭГ: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Сумын Засаг даргын 2020 оны А/23 дугаар Захирамжаар сумын “Шуурхай штаб”-ыг байгуулан онцгой комиссын гишүүдийг 2020 оны 02-р сарын 14-өөс 04-р сарын 30-ны өдрийг хүртэл 24 цагаар ажиллуулж мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь Онцгой байдлын газарт хүргүүлэн ажиллаж байна.



Шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэр, сумын Засаг даргын А/44 дүгээр захирамжаар засмал замын уулзвар дээр гэр барьж хяналтын цэгийг 3-р сарын 10-ны өдрөөс 16-ны өдрийн 07 цаг хүртэл ажиллуулах хугацаанд 257 тээврийн хэрэгсэл, 514 иргэн орж, 202 тээврийн хэрэгсэл, 430 иргэн гарч нийт 459 тээврийн хэрэгсэл, 944 иргэн хөдөлгөөнд оролцсон байна.



Алдарт эхийн 1, 2-р зэргийн одон шинээр авах иргэдийн материалыг сумын ИТХТ-ын хурлаар хэлэлцүүлж алдарт эхийн 1-р зэргийн одонг 2 иргэн, 2-р зэргийн одонг 8 иргэнд олгохоор боллоо.

Сумын Засаг даргын А/45 дугаар “0-12 настай хүүхэдтэй ажилтан албан хаагчдад цалинтай чөлөө олгох тухай” захирамжийн дагуу сумын 6 байгууллага 100 гаруй албан хаагчдыг 3-р сарын 31-ний өдрийг хүртэл ажлаас нь чөлөөлж, цахимаар ажил үүргээ гүйцэтгэж байна.

Сумын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж албан байгууллагуудын мэдээлэлтэй танилцан байгууллагуудын удирдлагуудад холбогдох чиглэлийн дагуу хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ


Сумын “Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх” дэд хөтөлбөрүүдийг 2020 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр ажлын хэсгийг хуралдуулан хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн 3 зорилтын хүрээнд 11 ажлыг 21 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу “Чанарын менежементийн тогтолцоо”-г нэвтэрүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар урилгыг хүргүүлээд байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 18 өвчтөн хэвтэж үүнээс 5-н хүүхэд хэвтэн эмчлүүлж байна. Эмнэлгийн үйлчилгээ нь:

- Амбулаторийн үзлэг – 231
- Дуудлага-118

Коронавирусийн халдварын сэжигтэй тохиолдлын үед ажиллах бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд эрүүл мэндийн төвийн халдвартын өрөөг



тусгаарлахаар 850000 төгрөгийн өртөг бүхий вакум хаалтыг сумын “Хүүхэд залуучуудыг дэмжих” дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэн хийлгэсэн.

Аймгийн мэргэжлийн хяналтын газар, эрүүл мэндийн газрын мэргэжилтэнүүд халдварын үед ажиллах бэлэн байдал нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавин ажилласан. Мөн ЭМГ-ын дарга, Эмийн мэргэжилтэн нар Коронавирусийн үед ажиллах эм эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдалд хяналт хийж ЭМЯ-аас хувиарлагдсан хамгаалах хэрэгсэл, халдваргүйтгэлийн 20 гаруй нэр төрлийн хэрэгсэлийг авчирч тусгаарлах өрөөний нөөцийг бүрдүүлээд байна.



Иргэдэд коронавирусээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэх үүднээс орон сууцны байрны орц бүрийн үүдэнд, давхар бүрт сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулан, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр өдөр бүр тогтмол мэдээллийг хүргэн ажиллаж байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж 4 иргэнийг тэтгэвэр тэтгэмжид, 1 өрхийг, “Хүнсний эрхийн бичиг”-ийн үйлчилгээнд хамруулахаар шийдвэрлэсэн байна.

Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдах өрхийн судалгааг 1, 2-р багийн Засаг дарга нараас авч нэгтгэн сумын ИТХ-д хүгүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 02-р сарын 20-ны өдрийн 16 тоот тогтоолоор “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т хамрагдах 16 өрхийг баталгаажуулсан.

Зорилтод бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичиг”-ээр хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх дэлгүүрийг сонгон шалгаруулж 2020 оны 2-р сарын 28-ны өдөр гэрээ байгуулсан. Мөн 2020 оны 3-р сарын 09-ний өдөр зорилтод бүлгийн иргэдэд сургалт зохион байгуулж 1-3-р сарын 3264000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан олгох ажлыг зохион байгуулан, тооцоо нийлж санхүүжилтыг шилжүүлсэн.



Аж ахуй нэгж байгууллагын сул, чөлөөтэй орон тооны захиалга ирүүлэх албан бичиг хүргүүлж, ажилгүй 1 иргэнийг ажил хайгчаар, 2 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан.

НИЙГМИЙН БОДЛОГО

Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрүүдийг 2020 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр ажлын хэсэг төлөвлөгөө хэлэлцэн “Хүүхэд, залуучуудыг дэмжих” дэд хөтөлбөр-ийг 5 зорилтын хүрээнд 21 ажлыг 10 сая төгрөгөөр, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн” дэд хөтөлбөрийг 2 зорилтын хүрээнд 14 ажлыг 10 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус хэрэгжүүлэхээр батлуулсан.

УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 22 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 5 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

3-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 5 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Нийт 41 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа аваад байна. Ингэснээр иргэд цаг хугацаа, эдийн засаг, санхүүгийн 410000 төгрөгийн хэмнэлтийг эдлээд байна.

Иргэдээс энэ сард 18 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө гаргаж аймгийн УБХ болон сумын Засаг даргын тамгын газрын даргад өгч баталгаажуулсан ба 1,2 сарын тайлан болон 1-р улирлын гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь гаргаж өгөөд байна.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2020 ОНЫ 03 САРЫН МЭДЭЭ

Шивээговь

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	24				24	10	14
Төрсөн эх	2	24				24		24
Бүртгүүлсэн гэр бүл	3	2				2	2	2
Нас баралт	4	6				6	6	-
Цуцалсан гэр бүл	5	1				1	1	1
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	16				16	8	8
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	-				-	-	-

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО**

2020.03.24.

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2020 оны 03-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
Дүн								
д/д	Үйлчилгээний нэр төрөл	Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд		Бүгд	Тайлбар
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
		1.	Иргэний үнэмлэх	15000	5	75000	3300	8
Дүн		105000			16500			
Нийлбэр дүн								
Нийт орлогын дүн				121500				

ХӨДӨӨ АЖ АХУЙ, МАЛ ЭМНЭЛЭГИЙН ТАСАГ



Төлийн мэдээг 7 хоног тутам гаргаж Аймгийн ХХААГ-т хүргүүлж байна. 03-р сарын 24-ний байдлаар ингэ-7, гүү-2, ямаа-2146, хонь-2677, үнээ-26, нийт 4858 мал төллөж, 4853 төл бойжиж 5 хурга хорогдсон байна. Том малын зүй бус хорогдол 43 байна.

Сумын Засаг даргын албан бичгээр “Нарлаг СӨХ”, “Тохилог СӨХ”-д орон сууцны байрнуудад ариутгал халдваргүйтгэл хийх үүрэг өгсөний дагуу орон сууцны 10 байрны 47 орц, 6 байрны техникийн давхарын 5700м² талбайд зориулалтын

бодисоор ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж 6 байрны 28 орцонд гар ариутгах шингэн байршуулан ажиллаж байна.



Сумын нийтийн эзэмшлийн газар болох төвийн дэлгүүрүүдийн урд талын 735,6м² хавтан талбайг ариутгалын бодисын 20%-ийн уусмалаар автомаксаар шүрших аргаар ариутгах ажлыг 2020 оны 03-р сарын 23-ны өдөр зохион байгууллаа.



БАЙГАЛЬ ОРЧИН

Бүх нийтийн их цэвэрлэгээг 2020 оны 03-р сарын 13-ны өдөр зохион байгуулж давхардсан тоогоор 15 аж ахуйн нэгж байгууллагын 77 иргэн 2 га талбайн 1,8 тн хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан. Мөн хогны машин болон хогийн 7 пункерт ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулсан.



